

Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурлын 2018 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 28 тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулан батлав.

МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧ, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ҮЭ-ИЙН ХОЛБООНЫ ШАГНАЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг.Ерөнхий зүйл

1. Салбарын ҮЭ-ийн холбооноос “Эрчим хүч, геологи, уул уурхайн тэргүүний мастер”, “Тэргүүний ажилтан” цол тэмдэг, “Хүндэт тэмдэг”, “Хүндэт жуух бичиг”-ээр шагнах болон “Хүндэт дэвтэр”-т бичихдээ энэхүү журмыг мөрдөнө.
2. Салбарын ҮЭ-ийн холбооны “Хүндэт дэвтэр”, “Эрчим хүч, геологи, уул уурхайн тэргүүний мастер”, “Тэргүүний ажилтан” цол тэмдэг, Хүндэт тэмдэг”, “Хүндэт жуух бичиг” олгох үндсэн зорилго нь Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн салбарын ажилтнууд, ҮЭ-ийн идэвхитэн, сонгуультны хөдөлмөрийн ололт амжилт, үр бүтээлийг үнэлэх, тэдний идэвхи санаачилгыг хөхүүлэн дэмжиж, сайшаан урамшуулахад оршино.
3. Шагналыг олгохдоо тус салбарын ажилтан, ҮЭ-ийн сонгуультны ажлын ололт, амжилт, үр бүтээлийг гол шалгуур үзүүлэлт болгохын зэрэгцээ тухайн ажилтны ажилладаг байгууллагын захиргаа, ҮЭ-ийн хорооны хөдөлмөр бүтээл, ажлын үр дүн, ҮЭ-ийн хөдөлгөөнд оруулсан хувь нэмрийг харгалзан үзэх зарчмыг баримтална.
4. Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбоо нь дараах шагналын төрөлтэй байна.
 - 4.1 “Хүндэт жуух бичиг”
 - 4.2 “Тэргүүний ажилтан” цол тэмдэг
 - 4.3 “Хүндэт тэмдэг”
 - 4.4 “Тэргүүний мастер” цол тэмдэг
 - 4.5 “Хүндэт дэвтэр”-т бичиж батламж олгох
 - 4.6 Мөнгөн шагнал буюу үнэ бүхий зүйлээр шагнах

Хоёр.Шагнал олгох ерөнхий нөхцөл

1. Эрчим хүч, геологи, уул уурхайн салбарт 1-5 хүртэл жил ажиллахдаа амжилт гаргасан ажилтан, ҮЭ-ийн сонуультаан, ахмад ажилтан, нийгмийн түншлэгч байгууллагын ажилтанг “Хүндэт жуух бичиг”-ээр шагнаж урамшуулна.
2. Эрчим хүч, геологи, уул уурхайн салбарт 5-аас доошгүй жил ажиллаж амжилт гаргасан ажилласан ажилтан, ҮЭ-ийн сонуультаан, ахмад ажилтанг “Хүндэт тэмдэг”-ээр шагнаж урамшуулна.
3. Эрчим хүч, геологи, уул уурхайн салбарт 8-аас доошгүй жил ажиллаж амжилт гаргасан ажилтан, ҮЭ-ийн сонгуультныг “Тэргүүний ажилтан” цол тэмдэгээр шагнаж урамшуулна.
4. ҮЭ-ийн болон Эрчим хүч, геологи, уул уурхайн салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан, ҮЭ-ийн орон тооны хорооны дарга, салбарын ҮЭ-ийн холбооны ажлын албаны ажилтнууд, салбарын гишүүн байгууллагын ажил олгогч, ажилтны алдар гавьяа, сайн үйлс, үлгэр дууриаллыг алдаршуулж, Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны “Хүндэт дэвтэр”-т алдар нэрийг нь мөнхүүлэн бичиж үлдээнэ. Хүндэт дэвтэрт бичигдсэн тухай батламж олгоно. Салбарын ҮЭ-ийн холбооны

Хүндэт дэвтэрт бичигдэх ажилтан салбарын ҮЭ-ийн холбооны шагналуудаар шагнагдсан байна.

5. Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбоо нь “Тэргүүний мастер” цол тэмдэг олгоходоо салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу салбарын яамтай хамтарсан журам батлан мөрдөж ажиллана.
6. Салбарын ҮЭ-ийн холбооны нэр хүндийг өргөсөн, ҮЭ-ийн байгууллагын хөгжил, санхүүгийн бие даасан байдлыг бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан, ҮЭ-ийн гишүүнчлэлийн эгнээг өргөтгөсөн, нийгмийн түншлэлийг бэхжүүлэхэд идэвхи зүтгэл, санаачлагатай ажилласан иргэн, гадаадын иргэн, ажил олгогчийг мөнгөн шагнал, үнэ бүхий зүйлээр шагнаж болно.

Гурав.Шагналд тодорхойлох, түүнийг хүлээн авах

1. Салбарын ҮЭ-ийн холбооны шагналаар шагнуулахаар өргөн мэдүүлж байгаа ажилтны ажил байдлын тодорхойлолтонд ажлын ололт амжилтыг дурьдсан байна.
2. Шагналд тодорхойлолтонд ҮЭ-ийн хорооны дарга, байгууллагын захирал гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулан Салбарын ҮЭ-ийн холбооны шагналын асуудал хариуцсан ажилтанд ирүүлнэ.
3. Шагнуулахаар өргөн мэдүүлэхдээ дараах материалыг бүрдүүлнэ.
 - 3.1 Шагнуулахаар өргөн мэдүүлсэн хүний анкет, ажил байдлын тодорхойлолт
 - 3.2 Шагнуулах тухай ҮЭ-ийн хорооны тодорхойлолт /ҮЭ-ийн хорооны дарга, ажилтныг шагнуулах бол байгууллагын тодорхойлолт/
 - 3.3 Шагнуулахыг дэмжсэн хурлын тэмдэглэл
4. Салбарын ҮЭ-ийн холбооны шагнал олгох ерөнхий журмыг хангаагүй тохиолдолд материалыг буцаана.
5. Шагналыг байгууллагын ой, салбарын болон ҮЭ-ийн өдрүүдээр олгох бөгөөд баяр болохоос 14-оос доошгүй хоногийн өмнө шагналын тодорхойлолтыг ирүүсэн байна.
6. Шагналын тодорхойлолт хугацаа хожимдож ирсэн тохиолдолд шагнал олгох эсэх асуудлыг түр хойшлуулна.
7. Салбарын ҮЭ-ийн холбооны гишүүн бус байгууллага ажилтнаа шагнуулсан тохиолдолд тэмдэг, үнэмлэхний зардалд 50,000 /гучин мянга/ төгрөг тушаана.
8. Салбарын ҮЭ-ийн холбооны шагнал хариуцсан ажилтан нэгдсэн бүртгэл хөтлөнө.

Дөрөв. Дагалдах мөнгөн шагналын хэмжээ

1. “Хүндэт жуух бичиг”, “Хүндэт тэмдэг”, “Тэргүүний ажилтан” цол тэмдэг, “Тэргүүний мастер” цол тэмдэгийн шагналын дагалдах мөнгөн шагналыг тухайн ажилтныг шагнуулахаар тодорхойлсон үндсэн байгууллага, ҮЭ-ийн хороо гаргана.
2. “Хүндэт жуух бичиг”-ийн дагалдах мөнгөн шагнал 50,000 /тавин мянга/, “Хүндэт тэмдэг”-ийн дагалдах мөнгөн шагнал 80,000 /наян мянга/, “Тэргүүний ажилтан” цол тэмдэг, “Тэргүүний мастер” цол тэмдэгийг 100,000 /нэг зуун мянга/ төгрөг дагалдана.
3. Салбарын ҮЭ-ийн холбооны “Хүндэт дэвтэр”-т бичигдсэн ажилтанд шагналын дагалдах мөнгө нэг сарын цалин байх бөгөөд ажил олгогч гаргана.

Тав. Шагналын тэмдэг, үнэмлэхийг нөхөн болон сольж олгох

1. Салбарын ҮЭ-ийн холбооны шагналын тэмдэг, үнэмлэхийг ямар нэг шалтгаанаар үрэгдүүлсэн, эвдэж гэмтээсэн тохиолдолд шагналын эзэн, ҮЭ-ийн хорооноос хүсэлтээ бичгээр гаргаж тэмдэг, үнэмлэхийг зохих үнээр нь олгоно.
2. Шагналын үнэмлэх, тэмдэгийг нөхөн болон сольж авахыг хүсвэл шагнагдсан ажилтан өргөдлөө салбарын ҮЭ-ийн холбоонд ирүүлнэ.
3. Салбарын ҮЭ-ийн холбооноос өргөдлийг хянаж үзээд нөхөн болон сольж олгох үндэслэлтэй гэж үзвэл нөхөн олгоно.

---оОо---

Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн ҮЭ-ийн холбооны Тэргүүлэгчдийн хурлын 2016 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 14 тоот тогтоолын 2 дугаар хавсралтаар батлав.

МЭХГУУ-Н ҮЭ-ИЙН ХОЛБООНЫ ШАГНАЛААР ШАГНУУЛАХААР ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ХҮНИЙ АНКЕТ

- 1.Овог
- 2.Нэр
- 3.Төрсөн огноо
- 4.Хүйс
- 5.Төрсөн аймаг, сум
- 6.Одоогийн харьяалал
- 7.Регистрийн дугаар
- 8.Ажилладаг салбар
- 9.Мэргэжил
- 10.Урьд болон одоо ажиллаж байгаа газар

№	Ажлын газрын нэр	Хугацаа /оноор	Эрхэлсэн ажил, албан тушаал
1			
2			
3			

- 11.Урьд болон шагнагдаж байсан шагналууд

	Шагналын нэр	Хэдэн онд
1		
2		
3		

- 12.Нэр дэвшүүлж байгаа шагналын нэр
- 13.Шагнуулах үндэслэл